


МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 22-өдөр

Дугаар A/191

Мандалговь

[] Эд хөрөнгө хүлээлцэх комисс томилох тухай []

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", "в", Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 76 дугаар тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 78 дугаар зүйлийн 78.2-ын "4", "7" дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн өмчит Нийтлэг үйлчилгээний үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгийг хүлээлцэх ажлыг 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор явуулсугай.

Хоёр. Үндсэн хөрөнгө хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Ц.Эрдэнэсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Ш.Оюун (Үйлчилгээний албаны дарга)

Гишүүд: П.Очирбат (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Д.Нандинцэцэг (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

Д.Даваа (Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Ч.Оюунсайхан (Архивын тасгийн сан хөмрөгч)

Б.Баатардорж (Засаг даргын Тамгын газрын нярав)

Э.Эрдэнэсүх (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Ё.Дашням (Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газрын дарга)

Т.Отгондулам (Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газрын нягтлан бодогч)

Ө.Энхтуяа (Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газрын нярав)

Гурав. Үндсэн хөрөнгө, бараа материалыг нэг бүрчлэн тоолж, фото зураг, дүрс бичлэгээр баримтжуулан холбогдох журам зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг комисс (Ц.Эрдэнэсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



482010515